

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

Сангийн яам  
Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар  
Ё.Амарбат

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

- Засгийн газрын өрийн удирдлага” гэж Засгийн газрын дунд болон богино хугацааны санхүүгийн зардал, эрсдэлийн түвшинг тодорхойлох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг ойлгоно.
- Өрийн удирдлагын бодлого, стратеги нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжихэд чиглэнэ.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ХЭМЖЭЭ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


- Засгийн газрын өрийн үлдэгдэл 2014 оны 3-р улирлын байдлаар 10.4 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа нь ДНБ-ний 48 хувийг эзэлж байгаа бол Засгийн газрын баталгааны үлдэгдэл ДНБ-ний 10.6 хувьтэй тэнцэж байна. 2015 оны Төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсанаар гадаад зээлийн хүрээнд 324.4 тэрбум төгрөгийн зээлийг авч ашиглахаар төсөвлөөд байна.

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2014	2015
<b>Засгийн газрын нийт өр /1+2+3+4+5/</b>		<b>09.30</b>	<b>Төсөв</b>
1	ЗГ-ын гадаад зээлийн өрийн үлдэгдэл	3,911.5	4,089.2
	1.1 Гадаад зээлийн ашиглалт	120.2	324.4
	1.2 Гадаад зээлийн өрийн үйлчилгээ	182.7	192.6
	1.2.1 Гадаад зээлийн үндсэн төлбөр	153.7	146.7
	1.2.2 Гадаад зээлийн хүүгийн төлбөр	28.9	45.9
2	ЗГ-ын дотоод үнэт цаасны өрийн үлдэгдэл	2,110.8	1,307.7
	2.1 Дотоодод шинээр гаргах үнэт цаас	1,334.1	-
	2.2 Дотоод үнэт цаасны үйлчилгээ	1,152.8	1,490.8
	2.2.1 Дотоод үнэт цаасны үндсэн төлбөр	1,043.7	1,224.2
	2.2.2 Дотоод үнэт цаасны хүүгийн төлбөр	109.1	266.6
3	Хөгжлийн банкнаас авсан дотоод өр/үлдэгдэл	908.9	1,251.2
4	ЗГ-ын гадаад үнэт цаасны өрийн үлдэгдэл	2,760.8	2,625.0
5	Татварын урьдчилгаа төлбөр	711.5	121.9
<b>Засгийн газрын өр</b>		<b>10,403.4</b>	<b>9,395.0</b>
<b>ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хувь</b>		<b>48.0%</b>	<b>39.2%</b>
<b>Засгийн газрын баталгаа</b>		<b>2,305.5</b>	<b>2,515.8</b>
<b>ЗГ-ын баталгааны ДНБ-д эзлэх хувь</b>		<b>10.6%</b>	<b>10.5%</b>
<b>Эдийн засгийн үзүүлэлт</b>			
Дотоодын нийт бүтээгдэхүүн-ДНБ (оны үнээр)		21,661.2	23,988.5
Ам.долларын төгрөгтэй харьцах ханш		1840.54	1750.00

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

Засгийн газрын өрийн хүүгийн зардалд улсын төсвөөс 2015 онд нийтдээ 707.9 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөөд байна:

## 2015 оны Засгийн газрын хүүгийн төлбөрийн зардлын задаргаа



# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД БАРИМТЛАХ БОДЛОГО, ЗАРЧИМ


- Монгол Улсын 2015-2017 оны төсвийн бодлого, баримтлах зарчмын хүрээнд Засгийн газрын өр, зээлийн талаарх дараах бодлогыг баримталж ажиллана:
  - Засгийн газрын гадаад зээллэгийн эх үүсвэрийг хамгийн бага зардлаар авах;
    - Гадаад орон, олон улсын байгууллагаас хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг тэргүүн ээлжид дайчилна.
    - Олон улсын байгууллагаас урт хугацаатай, хүү багатай арилжааны нөхцөлтэй зээлийг түлхүү авна.
    - Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг боломжит түвшинд эргэн төлөгдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлнэ.
  - Засгийн газрын өрийн багцын зохимжит бүтцийг бий болгох, валютын ханшны эрсдлийг бууруулах;
  - Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг бэхжүүлэх.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХАМГИЙН БАГА ЗАРДЛААР АВАХ ХҮРЭЭНД


## ■ Засгийн газрын өрийн өнөөгийн багц

Засгийн газрын өр  
/эх үүсвэрээр/


- Засгийн газрын гадаад өр
- Засгийн газрын дотоод өр



Засгийн газрын гадаад зээлийн өрийн үлдэгдэл  
/зээлдүүлэгчээр/



# ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХАМГИЙН БАГА ЗАРДЛААР АВАХ ХҮРЭЭНД



Монгол Улсын эдийн засаг хурдацтай өсч, нэг хүнд ногдох орлогын түвшин бага орлоготой улс орнуудын хувьд тогтоосон түвшингээс хэдэн жилийн турш давснаар дундаж орлоготой улсын эгнээнд орж, Дэлхийн банк (2012), Азийн хөгжлийн банк (2011) болон бусад эх үүсвэрүүдээс арилжааны нөхцөлтэй зээл авах боломжтой болсон. Олон улсын байгууллага, түнш орнуудаас авах нэн хөнгөлөлттэй зээл олгох санаачилга, эх үүсвэр байсаар байгаа боловч дунд хугацаанд эдгээр эх үүсвэр хаагдаж, Монгол Улс зөвхөн арилжааны нөхцөлтэй зээллэгийн эх үүсвэрт шилжих юм. Олон улсын байгууллага, түнш орнуудаас авч буй зээл нь нийгмийн суурь дэд бүтцийг санхүүжүүлэхэд тохирсон урт хугацааны, хүү багатай нөгөө талаас Монголын талаас төслийн менежментийг шаардах тул зээлийн эх үүсвэрийг ашиглах хариуцлагын тогтолцоог өндөрсгөж өгдөг давуу талуудтай байна.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХАМГИЙН БАГА ЗАРДЛААР АВАХ ХҮРЭЭНД

Зээлийн ангилал	Үнд/төл-өөс чөлөөлөгдөх хугацаа	Эргэн төлөгдөх хугацаа	Хүүгийн хэлбэр	Хүүгийн түвшин
Нэн хөнгөлөлттэй олон талт зээл	10	40	Тогтмол	0.75%
Хөнгөлөлттэй хоёр талт зээл	7	20	Тогтмол	2.00%
Арилжааны олон талт зээл	5	20	LIBOR+1.25	2.89%
Арилжааны банкны зээл	4	9	CIRR+1.5	3.14%
Гадаад үнэт цаас	0	10	Тогтмол	5.25%

- Гадаад зээлийн хувьд эргэн төлөгдөх хугацаа, хүүгийн түвшингээр хамгийн бага зардалтай нь нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй олон талт болон хоёр талт зээл байгаа бөгөөд түүний дараа арилжааны нөхцөлтэй олон талт зээл орж байна. Энэ хүрээнд 2014-2016 оны хооронд АХБ-наас 206.7 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл /ам.доллар/, 233.2 сая ам.доллар /төгрөгөөр/-ын арилжааны нөхцөлтэй зээл Дэлхийн банкнаас 114 сая ам.доллар /ам.доллараар/-ын хөнгөлөлттэй, мөн тус хэмжээний арилжааны нөхцөлтэй зээл /IBRD/-ийг тус тус Монгол Улсад олгож болохоор хуваарилалт хийгдсэн байна.




# ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙГ ДАМЖУУЛАН ЗЭЭЛИЙН БУЦААН ТӨЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ

Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2014 оны эхний хагас жилийн байдлаар 1.4 их наяд төгрөг байна.

Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээл /зээлдэгчээр/ 2014.06.30



Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээл /салбараар/ 2014.06.30



# ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙГ ДАМЖУУЛАН ЗЭЭЛИЙН БУЦААН ТӨЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ

- Тухайн салбарт төрөөс баримталж буй бодлого зохицуулалт болон зээлийг ашиглагч байгууллагын санхүүгийн чадамжаас шалтгаалж эргэн төлөлт муу байгаа зээлийн асуудлыг салбарын хэмжээнд цогцоор нь шийдвэрлэхээр яамд, бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд,
  - тухайн зээлийн хөрөнгийг ашигласан байгууллага, аж ахуйн нэгжийн эргэн төлөх чадварт эрсдэлийн үнэлгээ хийх,
  - зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах зэргээр зээлийн нөхцлийг хөнгөлсөн тохиолдолд эргэн төлөх боломжтой эсэх талаар санал, дүгнэлт гаргах гэх мэт.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙГ ДАМЖУУЛАН ЗЭЭЛИЙН БУЦААН ТӨЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ

- Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд уг асуудлыг Өрийн удирдлагын тухай хуулийн төсөлд дэд бүлэг болгон оруулж, тодорхой зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:
  - Хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг Сангийн яам, дэд зээлдэгч, эцсийн зээлдэгч хоорондын гурвалсан гэрээний үндсэн дээр олгох зохицуулалтыг тусгасан. Дэд зээлдэгч нь салбарын асуудал хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагч эсвэл, Хөгжлийн банк, Монголбанк, арилжааны банк, санхүүгийн байгууллагууд байх юм.
  - Зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлийг бууруулах үүднээс эцсийн зээлдэгчийн эргэн төлөх чадвартай эсэхэд эрсдэлийн үнэлгээ явуулах бөгөөд гагцхүү эргэн төлөх чадвартай нь тогтоогдсон этгээдэд дамжуулан зээлдүүлэх зарчмыг баримтална.
  - Дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хүлээх үүрэг, хариуцлага, зээлийн нөхцөл, шинж чанар, дэд зээлдэгчээс хамаарч дамжуулан зээлдүүлэх харилцаа хэрхэн зохицуулагдах талаар тодорхой тусгаснаас гадна холбогдох журмыг шинэчлэхээр ажиллаж байна.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ЗОХИМЖИТ БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ, ВАЛЮТЫН ХАНШНЫ ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ХҮРЭЭНД

- Засгийн газрын 2013 оноос хойш авсан иенээр илэрхийлэгдсэн өрийн эргэн төлөлтийг ам.долларт хөрвүүлэх чиглэлээр ажиллана.
- Олон улсын байгууллагаас төгрөгийн зээл авах арга замыг эрэлхийлж ажиллана.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ

- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг бэхжүүлэх хүрээнд:
  - Хоёрдогч хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг худалдах, худалдан авах, барьцаалах, шилжүүлэх, репо хэлцэл хийх үйл ажиллагааг хялбарчилж, зардлыг бууруулна.
  - Хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Засгийн газрын үнэт цаасны арилжаа явуулах захыг нээлттэй болгох, төлбөр, тооцооны тогтолцоог сайжруулах, кастодиан банкны үйл ажиллагааг бэхжүүлнэ.
  - Засгийн газрын урт хугацаат үнэт цаасны хэмжээг нэмэгдүүлж, нийт арилжааны 25-35 хувийг 3 жилийн хугацаатай, 20-30 хувийг 5 жилийн хугацаатай, 5-10 хувийг 10 жилийн хугацаатай арилжина.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- 2014 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар ЗГҮЦ-ны дийлэнхийг буюу 81.6%-ийг Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагын зорилгоор гаргасан үнэт цаас, 12.2 хувийг Хүний хөгжил сангийн үнэт цаас, 6.2 хувийг тусгай зориулалтын үнэт цаас эзэлж байна.


тэрбум төгрөг

№ ЗГҮЦ-ны нэр, төрөл	Үлдэгдэл 2014.09.30	Эзлэх хувь
<b>1 Тусгай зориулалтын үнэт цаас</b>	<b>132.80</b>	<b>6.20%</b>
1.1 4,000 айлын орон сууц хөтөлбөр	33.9	1.58%
1.2 Банкны бүтцийн өөрчлөлт	22.0	1.03%
1.3 Ноос, ноолуур, ЖДҮ-ийг дэмжих	12.0	0.56%
1.4 Засгийн газрын өрийн бичиг	64.9	3.03%
<b>2 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлага</b>	<b>1,746.90</b>	<b>81.62%</b>
2.1 Богино хугацаат /1 жил хүртэлх/	540.4	25.25%
2.2 Дунд хугацаат /1-ээс 5 жил хүртэлх/	1,174.5	54.87%
2.3 Урт хугацаат /10 жил/	32.0	1.50%
<b>3 Хүний хөгжлийн сангийн үнэт цаас</b>	<b>260.70</b>	<b>12.18%</b>
3.1 Дунд хугацаат	260.7	12.18%
<b>НИЙТ</b>	<b>2,110.40</b>	<b>100.00%</b>

- Засгийн газрын зүгээс цаашид урт хугацаат үнэт цаасны хэмжээг нэмэгдүүлэх, үнэт цаасны дундаж хугацааг сунгах чиглэлээр ажиллаж байна. Цаашид нийт арилжааны 25-35 хувийг 3 жилийн хугацаатай, 20-30 хувийг 5 жилийн хугацаатай, 5-10 хувийг 10 жилийн хугацаатай арилжаалах зорилттой байгаа.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ


- Засгийн газрын үнэт цаасыг зах зээлийн зарчмаар, тогтмол арилжаалж эхэлсэнээс хойш эрэлт ихээр нэмэгдсэн ба 2013 онд 2.6 их наяд төгрөг, 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 1.3 их наяд төгрөгийн үнэт цаасыг тус тус арилжаалаад байна.



- Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 2.1 их наяд төгрөгт хүрсэн.


# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ

### 3 сарын хугацаатай ЗГҮЦ




— Хамгийн өндөр хүү — Жигнэсэн дундаж хүү  
— Хамгийн бага хүү

### 6 сарын хугацаатай ЗГҮЦ




— Хамгийн өндөр хүү — Жигнэсэн дундаж хүү  
— Хамгийн бага хүү

### 1 жилийн хугацаатай ЗГҮЦ




— Хамгийн өндөр хүү — Жигнэсэн дундаж хүү  
— Хамгийн бага хүү

### 3 жилийн хугацаатай ЗГҮЦ




■ Купон — Хамгийн өндөр хүү  
— Жигнэсэн дундаж хүү — Хамгийн бага хүү

### 5 жилийн хугацаатай ЗГҮЦ



■ Купон — Хамгийн өндөр хүү  
— Жигнэсэн дундаж хүү — Хамгийн бага хүү

### 10 жилийн хугацаатай ЗГҮЦ



■ Купон — Хамгийн өндөр хүү  
— Жигнэсэн дундаж хүү — Хамгийн бага хүү




# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ

- Засгийн газрын үнэт цаасыг шаардлагатай үед нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэх болон тусгай зорилтот бодлогын арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор **зах зээлийн бус зарчмаар**, ихэнхи тохиолдолд **хаалттай** хэлбэрээр зардаг байсан.
- Засгийн газрын үнэт цаасыг зах зээлийн зарчмаар арилжаалж, тус зах зээлийг хөгжүүлэх нь дараах давуу талтай. Үүнд:
  - Үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн өр үүсгэснээр өрийн тогтвортой байдлыг бий болгох, өрийн багц дах валютын ханшны эрсдлийг багасгах;
  - Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг богино хугацаанд шийдвэрлэх;
  - Засгийн газрын үнэт цаасны хүүгийн түвшин нь зах зээлийн жишиг хүү болдог тул санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, санхүүгийн бусад төрлийн хэрэгсэл, бүтээгдэхүүнийг бий болгоход дэмжлэг болдог;
  - Сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зах зээлд дахин хуваарилах ажиллагааг дэмждэг.


# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ

- Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлд 2013 оны 5 дугаар сараас өнөөг хүртэл нийт 55 удаагийн 444.7 тэрбум төгрөгийн худалдах, худалдан авах хэлцэл хийгдсэн байна.

Хоёрдогч зах зээлийн хэлцэл



Репо хэлцэл



- Харин репо зах зээлийн хувьд 2014 онд нийт 77 удаагийн 2.1 их наяд төгрөгийн хэлцэл хийгдсэн бөгөөд энэ нь ихэнхидээ банкуудын хооронд хийгдсэн болно.
- Цаашид, хоёрдогч зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулахын тулд процедурыг хялбарчилж, зардлыг бууруулах, төлбөр тооцоо, хадгаламжийн бүрэн электронжуулж түргэн, шуурхай болгох ажлыг зохион байгуулж байна.

# ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

- Хуулийн төсөлд дараах шинэлэг заалтуудыг тусгаад байна:
  - Засгийн газрын өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоог бий болгох үүднээс өр үүсгэхээс эргэн төлөгдөх хүртэлх бүх харилцааг нарийвчлах.
  - Зээллэгийг өр үүсгэх зориулалттай нь уялдуулсан зохицуулалт буюу Засгийн газар, орон нутгийн гадаад, дотоод зээл, үнэт цаасны талаарх зохицуулалт, тавигдах шаардлагуудыг тодорхой болгох.
  - Засгийн газрын арилжааны нөхцөлтэй гадаад зээлийн хөрөнгийг аль болох эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй эргэн төлөх чадвартай төсөл, арга хэмжээнд дамжуулан зээлдүүлэх.
  - Өр үүсгэж бий болгосон хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, зээлийн төлбөрийг эргэн төлөхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхой болгох.
  - Өрийн удирдлагын ил тод байдлыг хангах, өрийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, олон нийтэд тогтмол мэдээллэх болон өрийн удирдлагын хэрэгжилтэд тавих хяналт мөн хууль, тогтоомж зөрчигчид хүлээлгэх.

# ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

- Өрийн бүтэц, түүний хязгаарын талаар доорх өөрчлөлтийг оруулахаар байна:
  - Засгийн газрын удирдах, хяналт тавих боломжтой өрийн бүтэц болох “Засгийн газрын өр”-ийг олон улсын жишгийн дагуу шинээр тодорхойлох;
  - Өрийн хязгаарыг өнөөгийн үнэ цэнээр тооцдог байсныг нэрлэсэн үнээр тооцдог болох;
  - Засгийн газрын баталгаа болон болзошгүй өр төлбөр гэсэн ойлголтыг нэр томъёоны хувьд Засгийн газрын газрын өрөөс салгаж, тусад нь хязгаарын түвшинг тогтоох.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА